



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР**

Засгийн газрын XII байрны баруун жигүүр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 36 28, Факс: (976-11) 31 03 70,
Цахим шуудан: info@mrgam.gov.mn,
Цахим хуудас: mrgam.gov.mn

2026.06.25 № 11/3732

танай _____-ны № _____-т

Үзлэг шалгалт хийх тухай

Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 10 дугаар албан даалгаврын дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөө батлагдаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. дэх хэсэгт “Байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч нь холбогдох хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллага, тухайн Хурал, Засаг даргын болон өөрийн шийдвэрийг байгууллагынхаа хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн дотоодын хяналт шалгалтын журам тогтоож ажиллана.” гэсний дагуу танай байгууллагын дотоод хяналт шалгалтын нэгжийг өөрсдийн үйл ажиллагаа явуулж байгаа ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд болон уурхай, үйлдвэрийн орчинд үзлэг шалгалтыг зохион байгуулж, үзлэг шалгалтын үр дүн болон арга хэмжээний тайланг 2026 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн дотор манай хэлтэст ирүүлнэ үү.



УУЛУУРХАЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

Т.ЗУУННАСТ

1578407778